



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 4 сарын 12 өдөр

Дугаар 89

Улаанбаатар хот

“Туусжам ББСБ” ХХК-ийг “Ашидтүвшин  
финанс ББСБ” ХХК-д нэгтгэхийг зөвшөөрч, “Туусжам ББСБ”  
ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.1, Компанийн тухай хуулийн 18, 20 дугаар зүйл, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.5, Хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 7.7.1, 7.7.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Туусжам ББСБ” ХХК-ийг “Ашидтүвшин финанс ББСБ” ХХК-д нэгтгэхийг зөвшөөрсүгэй.

2. “Туусжам ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

3. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, зохих бүртгэлийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Ашидтүвшин финанс ББСБ” ХХК /Ч.Сайхал/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН